



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Г “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг болон Захирал М.Түмэнжаргалтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал М.Түмэнжаргалтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай

3.“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Захирал М.Түмэнжаргалд хавсралтад заасны дагуу урамшуулалт олгосугай.

4.М.Түмэнжаргалд олгох урамшууллыг холбогдох зардлаас гаргахыг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ахлах нягтлан бодогч Б.Роломжавд зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд жяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132081327
11-r huraldaan.docx

Төрийн ёмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн
16. Дугаар толгоослын хавсралт

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН" ТӨРИЙН ёмчүүт ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг (мян.төг)	Цэвэр ашигийн дунгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал (мян.төг)	Урамшуулал тооцох цэвэр ашиг (мян.төг)	Олгох урамшууллын хэмжээ (мян.төг)
1	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ	M.Түмэнжаргал	113.206.500	3.467.400	109.739.130	7.194.780 (долпоон сая нэг зуун ерэн дөрвөн мянга долдоон зуун наян төгрөг)
.....000.....						